



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/375

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хуралдааны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Бохир усны шугам сүлжээний угсралтын ажил (Сайхан сум)-ыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан "Софт солар энерги" ХХК-тай 288,679,693 (хоёр зуун наян найман сая зургаан зуун далан есөн мянга зургаан зуун ерэн гурав) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3. Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Сайхан сумын Засаг дарга (Д.Сансар-Очир)-д үүрэг болгосугай.

4. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Софт солар энерги" ХХК-ийн захирал (Б.Уянга)-д даалгасугай.

5. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.


6. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010485

Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 22-ны/ний өдрийн А/ЗТЗ дугаар
захирамжийн хавсралт



д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	3,623,540	У.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	3,623,540	У.Бямбасүрэн
3	Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал	1,811,770	У.Бямбасүрэн
4	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	80,000,000	У.Бямбасүрэн
5	Нормчлолын сан	326,119	У.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Д.Батцогт У.Бямбасүрэн
8	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 32 хоног	У.Бямбасүрэн